



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН З А Х И Р А М Ж

2016 оны 9 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар
хот

Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагааны
стратеги, бүтцийн өөрчлөлтийн
хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9.1-д заасныг үндэслэн Засгийн газрын тохируулагч агентлаг-Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил

Засгийн газрын тохируулагч агентлаг-Үндэсний хөгжлийн газар (цаашид “газар” гэх)-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид “хөтөлбөр” гэх)-т Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, гадаадын хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, бүртгэл, концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого болон тус газрын хариуцсан бүсчилсэн хөгжлийн бодлого, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хувилбаруудыг Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутаг, орон нутгийн хөгжлийн бодлого болон салбарын хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулах, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах цогц үйл ажиллагаа хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын болон концессын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хөгжлийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн болон хөрөнгө оруулалтын чиглэлээр мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, сурталчлах асуудлыг хамарсан үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн “Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичиг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоол болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд боловсруулав.

1.3. Эрх зүйн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Засгийн газрын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;

- Хот байгуулалтын тухай хууль;
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль;
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Хөрөнгө оруулалтын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Концессын тухай хууль;
- Газрын тухай хууль;
- Өрийн удирдлагын тухай хууль;
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал;
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030;
- Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал;
- Бусад холбогдох хууль тогтоомж.

1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад практик шаардлага болон олон улсын арга зүй, төрийн захиргааны шинэчлэлийн удирдлага, үйл ажиллагааны онцлог, төлөвлөлт, зохицуулалтын арга зүйг ашиглаж, яам, Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги боловсруулж ирсэн туршлага, сургамж, үлгэрчилсэн загварыг харгалзсан болно.


1.5. Газрын үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь

Үндэсний хөгжлийн газар нь Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газарт Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээний болон тус газрын хариуцсан хөгжлийн бодлогын асуудлаар судалгаа, шинжилгээ хийх, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ. Үндэсний хөгжлийн газар нь үндэсний аюулгүй байдлыг хангахад нөлөөлөх хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, төр, хувийн хэвшлийн түншлэл байгуулах, хөгжлийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний урьдчилсан судалгаа хийх, хянан баталгаа хийх, үр дүнтэй төсөл, арга хэмжээ бүрт зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо хийх ажлыг зохион байгуулах, бодлогын удирдамжаар хангах асуудалд өргөн хүрээтэй, нарийн тооцоо судалгаатай хандаж, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг зөв зохистой төлөвлөхөд дэмжлэг үзүүлнэ.

1.6. Хөгжлийн стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээ шаардлага

Хөгжлийн стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр нь тус газрын ажил, үйлчилгээг авагч үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт, захиалга, даалгавар байхаар тодорхойлов. Эдгээр үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн бүлгийг дор дурдсанаар тодорхойлов:

**ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН СТРАТЕГИЙН
УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР**



Үндэсний хөгжлийн газрын үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Засгийн газар, Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байна. Үндэсний хөгжлийн газрын стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээ, шаардлага, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон гарах олон төрлийн харилцааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Үндэсний хөгжлийн газрын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээ шаардлагыг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээ, шаардлага тус бүрээр тогтоож, тус газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, албан хаагчдын ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод тус тус тусган хэрэгжүүлнэ.

Хоёр. Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагааны стратегийн зарчим нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон тус газрын хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хүрээний улс орны хөгжлийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт мэргэшлийн өндөр түвшний цаг үеэ олсон шуурхай зөвлөгөө өгөх, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Үндэсний хөгжлийн газар нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.2.1. эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний урьдчилсан судалгаа хийх, үр дүнтэй төсөл, арга хэмжээ бүрт зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо хийх ажлыг зохион байгуулах, бодлогын удирдамжаар хангах;

2.2.2. улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хувилбар төсөл боловсруулах, тодотгол хийх, хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний саналыг бэлтгэж, тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг тогтоох, хянан баталгаажуулах;

2.2.3. салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг боловсруулж, салбар хоорондын уялдааг хангах;

2.2.4. бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбар боловсруулж, бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах, салбарын хөгжлийн бодлогыг хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутаг, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулах;

2.2.5. хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хяналт тавих, хөрөнгө оруулалтын бодлого, хөрөнгө оруулалтад үзүүлэх дэмжлэг, арга хэмжээний санал боловсруулах, хөрөнгө оруулалтыг татах цогц үйл ажиллагаа хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаарх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, зохицуулах;

2.2.6. улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн талаар санал, дүгнэлт боловсруулах;

2.2.7. хөгжлийн төсөл, хөтөлбөрийн хувилбар боловсруулж хэрэгжилтийг хангах, хөрөнгө оруулалтын төслийн зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо, судалгаа хийх;

2.2.8. “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан”-г үүсгэж, эрхлэн хөтлөх;

2.2.9. тогтворжуулах гэрчилгээ эзэмшигчийн улсын бүртгэл хөтлөх, улсын хөрөнгө оруулалтын статистик мэдээллийг нэгтгэн гаргаж, хөрөнгө оруулалтын мэдээллийн санг үүсгэж, эрхлэн хөтлөх;

2.2.10. улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

2.3. Алсын хараа

Үндэсний хөгжлийн газар нь Монгол Улсыг үндэстний бие даасан байдлаа хадгалж хөгжсөн, өндөр бүтээмж, өрсөлдөх чадвартай олон тулгуурт салбар бүхий тогтвортой хөгжилтэй эдийн засагтай, байгаль экологийн тэнцвэртэй орчинд хүний эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн, нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн хөгжингүй улс болгох явдал мөн.

2.4. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Үндэсний хөгжлийн газрын эрхэм зорилго нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, хөрөнгө оруулалтын нэгдсэн болон концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг зөв зохистой төлөвлөж эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, салбарын хөгжлийн бодлогыг хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутаг, орон нутгийн хөгжлийн бодлого, хот байгуулалтын бодлоготой зөв уялдуулан экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан хүн амын ажиллаж, амьдрах эдийн засгийн таатай орчныг бий болгож, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх явдал мөн.

2.5. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Үндэсний хөгжлийн газар нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

2.5.1. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн бүсчилсэн хөгжлийн бодлогын болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хувилбар боловсруулах, батлуулах, хөгжлийн томоохон төслүүдийн саналыг нэгтгэн судалгааг зохион байгуулах, зохицуулах, бодлого, хөтөлбөр, төсөлд дүн шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах;

2.5.2. салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэл, бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбар санал боловсруулах, салбарын хөгжлийн бодлогыг хүн амын нутагшилт суурьшил, хот байгуулалт, бүс нутаг, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулах замаар салбар хоорондын уялдааг хангах, судалгаа, шинжилгээ хийх, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн санг эрхлэх;

2.5.3. хөрөнгө оруулалтын талаарх хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, улсын хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын болон концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогын хувилбар санал боловсруулах, хөрөнгө оруулалтын төслийг татварын болон татварын бус хэлбэрээр дэмжих санал боловсруулах;

2.5.4. хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл болон хөрөнгө оруулах нөхцөл, боломжийг дотоод, гадаадад сурталчлах, мэдээлэх цогц үйл ажиллагааг тасралтгүй эрхлэн явуулах, улсын хөрөнгө оруулалтын статистик мэдээллийг нэгтгэн гаргах, хөрөнгө оруулалтын мэдээллийн санг эрхлэн хөтлөх, хөрөнгө оруулагч нарт зөвлөгөө өгөх, мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.5.5. төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, улсын хөгжил, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

2.6. Үйл ажиллагааны гол зорилт

Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлнэ:

2.6.1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.6.1.1. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн бүсчилсэн хөгжлийн бодлогын болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хувилбар боловсруулах, батлуулах, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт жил бүр тодотгол хийх санал боловсруулах, бодлогын удирдамжаар хангах;

2.6.1.2. Засгийн газар, Ерөнхий сайдын өгсөн чиглэлийн дагуу дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, хөгжлийн бодлогын төсөөлөл, загвар боловсруулах, эдийн засгийн эрсдэлийг бууруулах, хамгаалах бодлогын хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангах;

2.6.1.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний урьдчилсан судалгаа хийх ажлыг зохион байгуулах, бодлогын удирдамжаар хангах;

2.6.1.4. улсын хөгжлийн бодлогын чиглэлээр судалгаа, тооцоолол хийх, төсөөлөл, загварчлал, зураглал боловсруулах ажлыг зохион байгуулах;

2.6.1.5. улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн талаар санал өгөх, дүгнэлт гаргах.

2.6.2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.6.2.1. бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбарын судалгаа, шинжилгээ хийх, бодлогын хувилбар боловсруулахад дэмжлэг үзүүлэх, бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах, хүн амын нутагшилт, суурьшил, хот байгуулалтын бодлогыг улсын эдийн засаг, нийгэм, үйлдвэржилтийн бодлоготой уялдуулах ажлыг зохицуулах;

2.6.2.2. салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн талаар судалгаа хийх, санал боловсруулах, салбар хоорондын уялдааг хангах, салбарын хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах ажилд дэмжлэг үзүүлэх, энэ чиглэлээр төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.6.2.3. үндэсний болон салбарын хөгжлийн төсөл, хөтөлбөрийн хувилбар, санал боловсруулж, хэрэгжилтийг хангах;

2.6.2.4. улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг тогтоох, хөрөнгө оруулалтын төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгаа, зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо, судалгаа хийх;

2.6.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтлөх, энэ зорилгоор хөгжлийн бодлогын төлөвлөлтийг талаар баримтлах чиглэлийг тодорхойлох, хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, мэдээллийн санд оруулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэх.

2.6.3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.6.3.1. хөрөнгө оруулалтын талаарх хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хөрөнгө оруулалтын зохистой, тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, хөрөнгө оруулалтад үзүүлэх дэмжлэг, арга хэмжээний санал боловсруулах;

2.6.3.2. улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн эхний хувилбар болон тодотгол хийх санал боловсруулах, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд шинээр болон үргэлжлэн хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг бэлтгэж, хянан баталгаажуулах;

2.6.3.3. олон талт, хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүд болон олон улсын хөрөнгө оруулалтын конвенцийн хэрэгжилтийг хангах, шинээр байгуулах гэрээ, хэлэлцээрийн талаар судалгаа хийх, санал боловсруулах;

2.6.3.4. хөрөнгө оруулалтын төслийг татварын болон татварын бус хэлбэрээр дэмжих санал боловсруулах, хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд тогтворжуулах гэрчилгээ олгох, бүртгэх, хяналт тавих, гадаадын төрийн өмчит компанид зөвшөөрөл олгох, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах;

2.6.3.5. улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийн талаар санал, дүгнэлт боловсруулах;

2.6.3.6. концессын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаарх бодлогын хувилбар боловсруулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө үзүүлэх.

2.6.4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.6.4.1. хөрөнгө оруулалтын бүртгэл болон статистик мэдээллийг холбогдох байгууллагаас авч нэгтгэх, судлах, хөрөнгө оруулалтын мэдээллийн санг эрхлэн хөтлөх, хэрэглэгчдэд мэдээлэх;

2.6.4.2. хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалттай холбоотойгоор төрийн бусад үйлчилгээний талаар зөвлөгөө өгөх, тэдэнд хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийхэд дэмжлэг үзүүлэх;

2.6.4.3. хөрөнгө оруулалтын талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл болон хөрөнгө оруулалтын нөхцөл, шаардлагыг гадаад, дотоодод төлөвлөгөөтэйгээр цогц байдлаар төрөл бүрийн арга, хэрэгслийг ашиглан сурталчлах;

2.6.4.3. гадаад орны хөрөнгө оруулалтын талаарх туршлага, санхүүгийн эх үүсвэрийн талаар судалгаа хийж, өөрийн улс орны эдийн засагт шаардлагатай хөрөнгө оруулалтыг сонгох, түүнийг татах үйл ажиллагааг зохион байгуулах талаар удирдлагад дэмжлэг үзүүлэх.

2.6.5. Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

2.6.5.1. төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, газрын үйл ажиллагааг нэгтгэн төлөвлөх,

хэрэгжилтийг зохион байгуулах, захиргааны нийтлэг үйлчилгээ, санхүү, аж ахуйн ажлыг зохицуулах;

2.6.5.2. хууль тогтоомж, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн гүйцэтгэл, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, хууль тогтоомжийн төсөл, хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах асуудлаар хууль зүйн дэмжлэг үзүүлэх;

2.6.5.3. төсвийн хэрэгжилтэд дотоод аудит, хяналт шалгалт хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх дүгнэлт, зөвлөмж өгөх.

2.7. Үйл ажиллагааны зорилт

Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагааны дээр дурдсан гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тодорхойлж, тус газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, албан хаагчийн ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод тусгаж хэрэгжүүлнэ.

2.8. Үйл ажиллагааны стратегийн загвар

Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагааны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЗАГВАР

2.9. Үйл ажиллагааны төлөвлөгөө

Үндэсний хөгжлийн газар нь өөрийн эрхэм зорилго, стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж ажиллана. Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө нь төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулах үр дүнгийн гэрээний салшгүй хэсэг байна.

Гурав. Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож байгаа зохион байгуулалтын бүтцийн загвар, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүрэг

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоог боловсруулахад баримтлах зарчим:

Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дараах зарчмыг баримтлав:

3.1.1. Үндэсний хөгжлийн газрын стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх зарчим (тухайн газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх);

3.1.2. эрх мэдлийн зааг, ялгаа нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байхын зэрэгцээ яамд болон бусад агентлагын зорилт, чиг үүрэгтэй давхардахгүй байх);

3.1.3. үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал, тухайн газрын бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

3.1.4. бүтцийн хувьд энгийн байх зарчим (тухайн газрын даргаас хамгийн доод нэгжээ хүртэл аль болох цөөн буюу 3-аас дээшгүй шат дамжлагатай байх);

3.1.5. тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (тухайн газрын үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломж бүрдүүлсэн байх);

3.1.6. улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим (тухайн газрын төрийн захиргааны албан хаагч нь газар, түүний удирдлага, Засгийн газар, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөгөө, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй байх);

3.1.7. хангалттай чадавх, үйл ажиллагааны бодитой зарчим (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц

нь чадавхиа бүрэн дүүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагааны стратегийн загварыг үндэслэн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны дараахь загварыг санал болгож байна:

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР



3.3. Зохион байгуулалтын бүтэц

Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн тус газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүргийг дор дурдсанаар тодорхойлж байна:

3.3.1. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн бүсчилсэн хөгжлийн бодлогын болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хувилбар боловсруулах, батлуулах, хөгжлийн томоохон төслүүдийн саналыг нэгтгэн судалгааг зохион байгуулах, зохицуулах, бодлого, хөтөлбөр, төсөлд дүн шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн бүсчилсэн хөгжлийн бодлогын болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хувилбар боловсруулах, батлуулах, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт жил бүр тодотгол хийх санал боловсруулах, бодлогын удирдамжаар хангах; Засгийн газар, Ерөнхий сайдын өгсөн чиглэлийн дагуу дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, хөгжлийн бодлогын төсөөлөл, загвар боловсруулах, эдийн засгийн эрсдэлийг бууруулах, хамгаалах бодлогын хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангах; эдийн засаг, нийгмийн

хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний урьдчилсан судалгаа хийх ажлыг зохион байгуулах, бодлогын удирдамжаар хангах; улсын хөгжлийн бодлогын чиглэлээр судалгаа, тооцоолол хийх, төсөөлөл, загварчлал, зураглал боловсруулах ажлыг зохион байгуулах; улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн талаар санал өгөх, дүгнэлт гаргах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний болон Үндэсний хөгжлийн газрын хууль тогтоомжоор хүлээсэн ажлын хүрээнд хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, судалгаа, шинжилгээ хийх, хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийг судлах, төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгаа, зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо, судалгаа хийх зэргээр шийдвэр боловсруулан гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон шуурхай зөвлөгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангахад чиглэгдэнэ.

Энэ нэгжийн үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Үндэсний хөгжлийн газрын дарга, улмаар Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, олон улсын байгууллага, аж ахуй эрхлэгч, иргэн байх болно. Үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Ерөнхий сайдын ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Гадаад харилцааны яам, Хөгжлийн банк байна.

3.3.2. салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэл, бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбар санал боловсруулах, салбарын хөгжлийн бодлогыг хүн амын нутагшилт, суурьшил, хот байгуулалт, бүс нутаг, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулах замаар салбар хоорондын уялдааг хангах, судалгаа, шинжилгээ хийх, хөгжлийн бодлогын баримт бичгийн мэдээллийн санг эрхлэх үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбарын судалгаа, шинжилгээ хийх, бодлогын хувилбар боловсруулахад дэмжлэг үзүүлэх, бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах, хүн амын нутагшилт, суурьшил, хот байгуулалтын бодлогыг улсын эдийн засаг, нийгэм, үйлдвэржилтийн бодлоготой уялдуулах ажлыг зохицуулах; салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн талаар судалгаа хийх, санал боловсруулах, салбар хоорондын уялдааг хангах, салбарын хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах ажилд дэмжлэг үзүүлэх, энэ чиглэлээр төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; үндэсний болон салбарын хөгжлийн төсөл, хөтөлбөрийн хувилбар, санал боловсруулж, хэрэгжилтийг хангах; улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг тогтоох, хөрөнгө оруулалтын төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгаа, зураг төсөв, техник, эдийн

засгийн үндэслэлийн тооцоо, судалгаа хийх; хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтлөх, энэ зорилгоор хөгжлийн бодлогын төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлох, хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, мэдээллийн санд оруулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг хэрэгжүүлнэ. Энэ нэгжийн зарим чиг үүргийн хүрээнд судалгаа, шинжилгээний нэгж ажиллана.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбар болон салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг боловсруулж салбар хоорондын уялдааг хангах, салбарын хөгжлийн бодлогыг хүн амын нутагшилт, суурьшил, хот байгуулалт, бүс нутаг, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулах талаар Үндэсний хөгжлийн газрын дарга, улмаар Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргыг шаардлагатай мэдээллээр хангах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Энэ нэгжийн үндсэн үйлчлүүлэгч нь Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуй эрхлэгч, иргэн, бусад хэрэглэгч байна. Үйлчилгээг үзүүлэхэд оролцогч гол түнш нь Ерөнхий сайдын ажлын алба, Сангийн яам, Гадаад харилцааны яам, бусад холбогдох яам, гадаадын элчин сайдын яамд, Монгол банк, Хөгжлийн банк, гадаад орны ижил төстэй байгууллага, судалгааны хүрээлэн байна.

3.3.3. хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд хөрөнгө оруулалтын талаарх хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, улсын хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын болон концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогын хувилбар санал боловсруулах, хөрөнгө оруулалтын төслийг татварын болон татварын бус хэлбэрээр дэмжих санал боловсруулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хөрөнгө оруулалтын талаарх хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хөрөнгө оруулалтын зохистой, тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, хөрөнгө оруулалтад үзүүлэх дэмжлэг, арга хэмжээний санал боловсруулах; улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн эхний хувилбар болон тодотгол хийх санал боловсруулах, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд шинээр болон үргэлжлэн хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг бэлтгэж, хянан баталгаажуулах; олон талт, хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүд болон олон улсын хөрөнгө оруулалтын конвенцийн хэрэгжилтийг хангах, шинээр байгуулах гэрээ, хэлэлцээрийн талаар судалгаа хийх, санал боловсруулах; хөрөнгө оруулалтын төслийг татварын болон татварын бус хэлбэрээр дэмжих санал боловсруулах, хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд тогтворжуулах гэрчилгээ олгох, бүртгэх, хяналт тавих, гадаадын төрийн өмчит компанид зөвшөөрөл олгох, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах; улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийн талаар санал, дүгнэлт боловсруулах; концессын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаарх бодлогын хувилбар боловсруулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө үзүүлэх чиг үүрэг хэрэгжүүлнэ. Энэ нэгжийн зарим чиг үүргийн хүрээнд концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн нэгж ажиллана.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь улсын хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, бүс нутгийн хөгжлийн бодлого, талуудын хөрөнгийн эх үүсвэртэй зөв зохистой уялдуулж, хөрөнгө нөөцийн үр ашгийг дээшлүүлж, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах талаар Үндэсний хөгжлийн газрын даргыг, улмаар Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргыг шаардлагатай мэдээллээр хангах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Энэ нэгжийн үндсэн үйлчлүүлэгч нь Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, олон улсын болон бүс нутгийн байгууллагууд, санхүү, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид болон аж ахуйн нэгж, иргэн, бусад хэрэглэгч байна. Үйлчилгээг үзүүлэхэд оролцогч гол түнш нь Ерөнхий сайдын ажлын алба, Сангийн яам, бусад холбогдох яам, Монгол банк, Хөгжлийн банк байна.

3.3.4. бүртгэл, мэдээлэл, сурталчилгааны асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл болон хөрөнгө оруулах нөхцөл, боломжийг дотоод, гадаадад сурталчлах, мэдээлэх цогц үйл ажиллагааг тасралтгүй эрхлэн явуулах, улсын хөрөнгө оруулалтын статистик мэдээллийг нэгтгэн гаргах, хөрөнгө оруулалтын мэдээллийн санг эрхлэн хөтлөх, хөрөнгө оруулагч нарт зөвлөгөө өгөх, мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хөрөнгө оруулалтын бүртгэл болон статистик мэдээллийг холбогдох байгууллагаас авч нэгтгэх, судлах, хөрөнгө оруулалтын мэдээллийн санг эрхлэн хөтлөх, хэрэглэгчдэд мэдээлэх; хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалттай холбоотойгоор төрийн бусад үйлчилгээний талаар зөвлөгөө өгөх, тэдэнд хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийхэд дэмжлэг үзүүлэх; хөрөнгө оруулалтын талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл болон хөрөнгө оруулалтын нөхцөл, шаардлагыг гадаад, дотоодод төлөвлөгөөтэйгээр цогц байдлаар төрөл бүрийн арга, хэрэгслийг ашиглан сурталчлах; гадаад орны хөрөнгө оруулалтын талаарх туршлага, санхүүгийн эх үүсвэрийн талаар судалгаа хийж, өөрийн улс орны эдийн засагт шаардлагатай хөрөнгө оруулалтыг сонгох, түүнийг татах үйл ажиллагааг зохион байгуулах талаар удирдлагад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалтыг цогц байдлаар үр дүнтэй, тасралтгүй мэдээлэх, сурталчлах талаар Үндэсний хөгжлийн газрын даргыг, улмаар Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргыг шаардлагатай мэдээллээр хангах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Энэ нэгжийн үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь Үндэсний статистикийн хорооны холбогдох нэгж, бусад яамдын ижил төстэй зохион байгуулалтын бүтцийн нэгж, бусад агентлаг, олон улсын болон ижил төстэй байгууллага, гадаад, дотоодын хөрөнгө оруулагч,

бизнес эрхлэгчид байна. Үйлчилгээг үзүүлэхэд оролцогч гол түнш нь Ерөнхий сайдын ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Гадаад харилцааны яам, бусад яам байна.

3.3.5. захиргаа, удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, улсын хөгжил, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, газрын үйл ажиллагааг нэгтгэн төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, захиргааны нийтлэг үйлчилгээ, санхүү, аж ахуйн ажлыг зохицуулах; хууль тогтоомж, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн гүйцэтгэл, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, хууль тогтоомжийн төсөл, хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах асуудлаар хууль зүйн дэмжлэг үзүүлэх; төсвийн хэрэгжилтэд дотоод аудит, хяналт шалгалт хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх дүгнэлт, зөвлөмж өгөх чиг үүрэг хэрэгжүүлнэ. Энэ нэгжийн зарим чиг үүргийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж ажиллана.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь төрийн захиргааны манлайллыг хангах, цомхон, чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэшсэн албаны хүчээр Үндэсний хөгжлийн газрын ажлын тасралтгүй, хэвийн, жигд, шуурхай ажиллагааг хангах, хөгжлийн болон хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд чиглэнэ. Энэ нь газрын удирдлага болон зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдлага, ажилтанд шийдвэр боловсруулж гаргах, хэрэгжүүлэхэд хууль зүйн дэмжлэг, дотоод нийтлэг үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, үндэсний хөгжил, салбарын хөгжил, хөрөнгө оруулалтын бодлогын чиглэлээр ажиллах мэргэжилтэнг бэлтгэх, давтан бэлтгэх, мэргэшүүлэх, тэдний нийгмийн баталгааг бий болгоход дэмжлэг үзүүлэх, удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Үндэсний хөгжлийн газрын удирдлага, газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, төрийн захиргааны албан хаагч байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын холбогдох агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бусад хэрэглэгчид байна. Үйлчилгээ үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, сургалтын болон эрдэм шинжилгээний байгууллага байна.